УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Г.БАТЗОРИГ

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖИНД НЭГ НАСТ ЦЭЦЭГТ БАЙГУУЛАМЖИЙН ЦЭЦЭГ ХУДАЛДАН АВАХ, АРЧЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 04 дугаар сарын 16-ний өдөр Улаанбаатар хот

1	**Ажлын даалгавар гаргах үндэслэл**	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 24/33 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Улаанбаатар хотын Ерөнхий менежер 2025 оны Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн төсөл арга хэмжээ зохион байгуулах тухай А/43 дугаар тушаал, Монгол Услын стандарт MNS 6259:2011 болон бусад холбогдох хууль журам
2	**Үндсэн ойлголт**	Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.5.4. Хотын ногоон байгууламжийг хамгаалах, нэмэгдүүлэх, хотын соёл бүрдүүлэх иргэдийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд Нийтийн эзэмшлийн цэцэрлэгжүүлсэн болон сул шороон талбайд хотын өнгө үзэмж харуулсан гоёл чимэглэлийн нэг наст цэцгийн зохиомж хийх.
3	**Барилгын байгууламжийн байршил**	Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, талбайд
4	**Зориулалт, хүчин чадал**	Нийтийн эзэмшлийн талбайн 20 байршилд 321,400 ширхэг нэг наст цэцэгт тарих, арчлах.
5	**Төслийн гүйцэтгэх хугацаа**	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	**Ажлын цар хүрээ, явц**	Нийтийн эзэмшлийн цэцэрлэгжүүлсэн болон сул шороон талбайд хотын өнгө үзэмж харуулсан гоёл чимэглэлийн нэг наст цэцгийн зохиомж хийх бөгөөд талбайд тарилт хийхээс хураалт хүртэлх цэцгийн тарилт, арчилгаа, хамгаалалт, нөхөн тарилт, 3d зохиомжийн суурилуулалт, хураалтын тээвэр аюулгүй байдлыг бүрэн хариуцаж намар хүлээлгэн өгнө.

7 Цэцэгний нэр төрөл

№	Нэг наст цэцгийн үрслэгийн нэр	Нийт /ширхэг/	Өнгө	Өндөр /см/	Хэмжих нэгж /ширхэг/	Багц
1	Хилэнжин, Зөгийн үүр	15,000	Улбар шар	15-20	7,500	**Багц-1** 80,350 ширхэг
2			Шар	15-20	7,500	
3	Алаг нүдэн:	14,000	Холимог	15-20	14,000	
4	Элит хун:	8,000	Холимог	15-20	8,000	
5	Petunia буюу Хун цэцэг:	38,000	Улаан	15-20	10,000	
6			Цагаан		10,000	
7			Ягаан		8,000	
8			Нил ягаан		10,000	
9	Астра цэцэг:	6,400	Ягаан	8-15	2,000	
10			Улаан	8-15	3,350	

11	**Дүн**				**80,350**		
12	Petunia буюу Хун цэцэг:	40,000	Улаан	15-20	10,000	**Багц-2** 80,350 ширхэг	
13			Цагаан	15-20	10,000		
14			Ягаан	15-20	10,000		
15			Нил ягаан	15-20	10,000		
16	Астра цэцэг:	10,000	Улаан	8-15	5,000		
17			Ягаан	8-15	5,000		
18	Хилэнжин, Зөгийн үүр	10,000	Шар	15-20	10,000		
19	Цинния буюу Хүмээс цэцэг	5,000	Холимог	15-20	5,000		
20	Мандарваа цэцэг:	15,000	Холимог	15-20	15,350		
21	**Дүн**				**80,350**		
22	Хилэнжин, Зөгийн үүр	5,000	Улбар шар	15-20	2,500	**Багц-3** 80,350 ширхэг	
23			Шар	15-20	2,500		
24	Бербиния:	5,000	Улаан	15-20	2,000		
25			Цагаан	15-20	2,000		
26			Нил ягаан	15-20	1,350		
27	Астра цэцэг:	3,000	Холимог	8-15	3,000		
28	Хулгана сүүл:	10,000	Улаан	15-20	10,000		
29	Алаг нүдэн:	20,000	Холимог	15-20	20,000		
30	Мандарваа цэцэг:	15,000	Холимог	15-20	15,000		
31	Тахиан залаа:	7,000	Холимог	8-15	7,000		
32	Хун давхар дэлбээт:	7,500	Улаан	15-20	7,500		
33		7,500	Ягаан	15-20	7,500		
34	**Дүн**				**80,350**		
35	Хилэнжин, Зөгийн үүр	5,000	Улбар шар	15-20	2,500	**Багц-4** 80,350 ширхэг	
36			Шар	15-20	2,500		
37	Астра цэцэг:	3,000	Улаан	8-15	1,000		
38			Ягаан	8-15	2,000		
39	Бербиния:	5,000	Улаан	15-20	2,000		
40			Цагаан	15-20	2,000		
41			Нил ягаан	15-20	1,350		
42	Хулгана сүүл:	10,000	Улаан	15-20	10,000		
43	Алаг нүдэн:	20,000	Холимог	15-20	20,000		
44	Мандарваа цэцэг:	15,000	Холимог	15-20	15,000		
45	Тахиан залаа:	7,000	Холимог	8-15	7,000		

		46	Хун давхар дэлбээт:	15,000	Улаан	15-20	7,500	
		47			Ягаан	15-20	7,500	
		48	**Дүн**				**80,350**	

8	**Хийц ажлын зохион байгуулалт**	- Үрлэсэн цэцгийн талбайд шууд тарихад амьдралт муу учраас 4-р сарын сүүл, 5-р сарын эхээр гадны нөхцөлд аажмаар дасгана. - Үрслэг нь мөчирлөлт сайтай, богино иштэй тээвэрлэлт, шилжүүлэн суулгалт сайн даахаар сайн чанарын шилбэ бүдүүн ил хөрсөнд суулгахаар бэлтгэнэ. - Үрслэг суулгах талбайн ил хөрсийг 20-25см гүн хагалж чулуу хог ургамлын үндсийг нь түүж цэвэрлээд, багсармал бордоог хольж чийглэн тэгшилсэн байна. - Үрслэгийг задгай талбайд цочир хүйтрэлт өнгөрсний дараа 6 дугаар сараас гадна агаарын хэм +10 болсон үеэс эхлэн шилжүүлэн суулгана. - Үрслэгийг цэцгийн онцлог дэлбээ, 10-15 ширхэгийг 1м2 талбайд 50-70 ширхэг байхаар суулгана. - Хөрсийг нягтрахаас сэргийлж 7 хоногт 1 удаа сийрүүлж хог ургамлыг түүх. - Усалгааг үрслэг суулгасны дараа агротехнологийн дагуу өглөө оройн цагаар хийнэ. - Талбайд гаргасан цэцэг арчилгаагүй, хоргодол ихтэй сийрэг хатсан бол захиалагчид нийлүүлэх тоо хэмжээнд хамааралгүй өөрийн зардлаар нөхөн тарилтыг хийнэ. Гадаад байдал: Гадна талын байдал 2-3 цэцгийн дэлбээ ургасан, бусад ишнээс салаалсан салаа бүр бундуй үүссэн. Шалбарч, хугарч гэмтээгүй, шарлаж хорчийж харлаагүй, эрхтэн нь өвчин хортон, хөнөөлт шавьжинд нэрвэгдээгүй үрийн шинжилгээний бичиг хавсаргасан байна. Хэлбэр: Зөв ургалттай, иш бүрээс олон салаа цэцэг гарах чадвартай, нахиа түрсэн ба 2-3 цэцэг гарсан зөв хэлбэртэй байна. Өнгө: Загвар дизайн гаргахад тохиромжтой тод гоёмсог өнгөтэй байна. Тухайлбал: цагаан, улаан, ягаан, нил ягаан, шар, хөх гэх мэт Үрслэгийн хэмжээ: • Үндсэн цэцгийн дэлбээний тоо 5-12 ширхэг • Цэцгийн шилбэний өндөр 0.5-15 см хүртэл • Дэлбээний диаметр 2-6 см ба түүнээс дээш Үндэс: Өсөлт хөгжилт сайтай бүдүүн иштэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндсийг үржил шимтэй шороотой нь хамт авна. Ачилт тээвэрлэлт: Цэцгийн дэлбээ иш, нахиаг хугалж гэмтээхгүй бүрэн бүтэн тээвэрлэнэ. Цэцгийн үрслэгийг зориулалтын бортогонд суулгасан байдлаар нийлүүлэх */биет зохиомж, хийцлэл дээр дүрс үүсгэхэд тохиромжтой үндэс хамгаалсан/* Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан, холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баримтжуулаагүй, хийгдсэн ажлын тайланд тусгагдаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Нөгөө талаас холбогдох БНбД-үүд, техник технологийн стандартуудад заасан шаардлагуудыг хангаж ажиллахыг анхаарна уу.

9	**Захиалагч байгууллага**	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
10	**Онцгой нөхцөл**	- Техникийн тодорхойлолтод заасан бараа материалын хүчин чадал тоо хэмжээг хангаж ажиллах. - Цэцэг нь иш богино бүдүүн, үндсэний систем сайн өвчин хортонд өртөөгүй, механик гэмтэлгүй байх. - Үрслэгийг ургаж буй хайрцагтай нь тээвэрлэнэ. - Үрслэгийг өөр саванд савлах шаардлагатай бол сайтар услаад үндэсний шороотой авч, савлах хайрцагандаа чигжүү өрж тавина. - Тээвэрлэсэн суулгацыг мандал хийх талбайд тухайн өдөртөө багтааж суулгана. - Цэцгийн мандалд тавих хийцлэлүүдийн ачих буулгах тээвэрлэлтийн зардал хариуцах бөгөөд ачиж буулах, тээвэрлэхэд гарсан гэмтэл, хохиролыг бүрэн хариуцах албан тоот ирүүлэх. - Суулгацын нөөц, ургалтын байдалтай захиалагчаас санал ирүүлсэн оролцогчийн талбайтай танилцах, нөөцийн хэмжээг хүчин чадлыг харгалзан үзэх
11	**Эдийн засгийн тооцоо, төсөв**	Төсвийг тооцож ирүүлэх.

ХЯНАСАН:

ТОХИЖИЛТ, ХОГ ХАЯГДЛЫН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.БИЛГҮҮН

БОЛОВСРУУЛСАН:
ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.БАТЖАРГАЛ